



**ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 54

Ховд

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.1.8, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ЗАМ” аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцын үр дүнгийн тайланг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж, үнэлэлт, дүгнэлт өгч ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (З.Эрхбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Аймгийн Засаг дарга (М.Амарсанаа)-д үүрэг болгосугай.

3.1 Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, холбогдох хөгжлийн баримт бичгүүдтэй уялдуулан жил бүрээр, хариуцах эзэн, шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан тусган баталж, хэрэгжилтийг ханган ажиллах.

3.2 Үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтууд, 10 томоохон төслүүдийг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган нутгийн удирдлага, төрийн захиргаа, төсөвт болон төсөл, хөтөлбөрийн байгууллагууд, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүд, иргэдийн санал санаачилгыг өрнүүлэн хэрэгжилтийг зохион байгуулах.

3.3 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн хэрэгжилтийг үр дүнг тооцож, биелэлтийг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.

3.4 Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг иргэд олон нийтэд өргөн сурталчилж, нийтийн хүртээл болгох.

Дөрөв. Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт Зөвлөх нь:

4.1 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлуудыг сумын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусган иргэд, байгууллагуудын санал, санаачилгыг өрнүүлэн хэрэгжилтийг ханган ажиллах.

Тав. Сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, орон нутгийн өмчийн газрын дарга нарт ДААЛГАХ нь:

5.1 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан өөрийн сум, байгууллагатай холбогдол бүхий заалтуудыг хяналтад авч, хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг бүх шатны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусган үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцон аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байх.

Зургаа. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллахыг иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, нийт иргэдэд уриалсугай.

ХУРЛЫН ДАРГА



З.ЭРХБАЯР